Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 13,363,585.0 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 179,905.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	56,626.6	22,534.6	-34,092.0
Бараа материал	285,336.6	149,942.3	-135,394.3
Нөөцийн бараа	23,119.5	98,708.8	75,589.3
Үндсэн хөрөнгө	15,253,127.4	15,518,130.9	265,003.5
Хуримтлагдсан элэгдэл	-2,074,719.9	-2,425,731.6	-351,011.7
Нийт хөрөнгө	13,543,490.2	13,363,585.0	-179,905.2
Өр төлбөр	0.0	103,755.2	103,755.2
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	13,543,490.2	13,259,829.8	-283,660.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,543,490.2	13,363,585.0	-179,905.2

Дээрх хүснэгтээс харахад, авлага дансны үлдэгдэл 22,534.6 мянган төгрөг байгаа нь "Натурал грийн фүүдс" ХХК-иас авах гэрээний авлага 10,000.0 мянга, байгууллагуудаас авах архивын бланкны орлого 8,199.3 мянга, нэмэлт санхүүжилтийн дансны авлагыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 4,335.3 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 149,942.3 мянган төгрөг болж өмнөх оноос 135,394.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 338,889.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар иргэн, бусад байгууллагаас 36,274.9 төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 314,811.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 120,158.1 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 98,708.8 мянган төгрөг болж өмнөх оноос 75,589.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 75,589.3 мянган төгрөгөөр хийгдсэн шуурхай удирдлагын төвийн камержуулалтыг аймгийн ИТХ-ын тогтоол гараагүйгээс нөөц бараа дансанд бүртгээгүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,518,130.9 мянган төгрөг болж 265,003.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 369,977.0 мянга, бусад байгууллагаас 465,937.8 мянган (аймгийн ИТХ-ын 2025.03.11-ний өдрийн 5/05 дугаар тогтоолоор 14,959.7 мянга, аймгийн ИТХ-ын 2025.08.26-ны өдрийн 8/52 дугаар тогтоолоор 241,246.9 мянга, аймгийн ИТХ-ын 2025.12.25-ны өдрийн 10/77 дугаар тогтоолоор 206,618.0 мянга, төрийн албаны зөвлөлөөс 3,113.2 мянга) төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, аймгийн ИТХ-ын 2025.06.12-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 7/40 дугаар тогтоолоор 139,650.0 мянган төгрөгийн бусад байгууллагад шилжүүлж, аймгийн ИТХ-ын 2025.03.11-ний өдрийн "Хөрөнгө акталж, данснаас хасах тухай" 5/04 дүгээр тогтоолоор 349,564.3 мянга, аймгийн ИТХ-ын 2025.12.01-ний өдрийн "Хөрөнгө акталж, данснаас хасах тухай" 9/60 дугаар тогтоолоор 81,696.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 103,755.2 мянган төгрөг байгаа нь 2025 оны 11, 12 дугаар сарын зардлын эрхийг Сангийн яам хааж гүйлгээ зогссоноос 17 иргэн, аж ахуйн нэгжид өр төлбөртэй гарсан байна.

Хүснэгт 2. Өр төлбөрийн задаргаа

(мянган төгрөгөөр)

№	Байгууллага, иргэний нэр	Өр төлбөрийн дүн
Төсвийн өр төлбөр		
1	Юнившн	2,200.0
2	Оюу номин хорол ХХК	2,900.0
3	Хадат бодь	3,000.0
4	НИК ХХК	4,000.0
5	Өлзийтийн хийморь өөдөө	1,500.0
6	Ному ган медиа	1,500.0
7	Занданбал	1,000.0
8	Татварын хэлтэс /Газрын төлбөр/	845.4
9	Болорчимэг /тэтгэвэрийн зөрүү/	1,215.6
10	Рашаант хайрхан ХХК	14,094.2
	Төсвийн нийт өр төлбөр	32,255.2
Жилийн хөгжлийн төлөвлөгөөний өр төлбөр		
1	ЭМГазар	1,380.0
2	Боловсролын газар	17,000.0
3	Хатан форест ХХК	20,000.0
4	Сонинбаяр	5,775.0
5	Идэрбаясгалан	12,000.0
6	БТОЗ	345.0
7	Авто тээвэр	15,000.0
	Жилийн хөгжлийн төлөвлөгөөний нийт өр төлбөр	71,500.0
	Нийт дүн	103,755.2

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 283,660.4 мянган төгрөгөөр буурч 13,259,829.8 мянган төгрөг болсон байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Санхүүгийн тооцоолох төвийн "Acolous" программыг ашигладаг ба тайлант онд 737.0 мянга, бичиг хэргийн үйл ажиллагаанд ашигладаг 3 программын сунгалтад 421.0 мянга, архивын программын сунгалтад 160.0 мянга, вирусийн болон оффисын программд 9,240.0 мянган нийт 10,558.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 5,068,232.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 30,000.0 мянга нийт 5,098,232.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 5,098,232.9

мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2 удаа тодотгол хийж орон нутгийн төсвөөс 7,487,924.3 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 45,000.0 мянга, урьд оны үлдэгдлээс 440,000.0 мянга нийт 7,972,924.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 7,487,924.3 мянга, урд оны үлдэгдлээс 440,000.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 45,000.0 мянга нийт 7,972,924.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 7,782,069.3 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 86,143.6 мянга нийт 7,868,212.9 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,816,001.2 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 52,211.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын 2025.08.26-ны өдрийн “Баянхонгор аймгийн 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 8/45 дугаар тогтоолоор жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 50 төсөл ,арга хэмжээг 2,248,859.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба аймгийн Засаг даргын 2025.12.16-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/662 дугаар захирамжаар 2,077,333.7 мянган төгрөг болгон өөрчилсөн байна. Гүйцэтгэлээр 2,003,320.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	7,972,924.3	7,816,001.2	156,923.1	98.0
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	4,833,664.5	4,803,697.9	29,966.6	99.4
1.1	2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,481,335.0	3,474,825.3	6,509.7	99.8
1.2	2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	419,729.4	419,729.4	-	100.0
1.3	2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	413,969.3	413,854.0	115.3	100.0
1.4	2104 Хангамж, бараа материалын зардал	175,966.3	166,900.0	9,066.3	94.8
1.5	2105 Нормативт зардал	5,000.0	5,000.0	-	100.0
1.6	2106 Эд хогшил худалдан авах	102,154.9	102,154.9	-	100.0
1.7	2107 Томилолт, зочны зардал	112,000.0	101,064.3	10,935.8	90.2

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
1.8	2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	41,502.0	38,504.8	2,997.2	92.8
1.9	2109 Бараа үйлчилгээний бусад зардал	82,007.6	81,665.2	342.4	99.6
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	36,000.0	30,000.0	6,000.0	83.3
2.1	210801 Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	36,000.0	30,000.0	6,000.0	83.3
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	58,926.1	49,526.0	9,400.1	84.0
3.1	213204 Бусад ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	24,000.1	14,600.0	9,400.1	60.8
3.2	213207 Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	34,926.0	34,926.0	-	100.0
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	967,000.0	929,456.9	37,543.1	96.1
4.1	210901 Бараа үйлчилгээний бусад зардал	967,000.0	929,456.9	37,543.1	96.1
5	81104 Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө	2,077,333.7	2,003,320.3	74,013.4	96.4
5.1	210901 Бараа үйлчилгээний бусад зардал	2,077,333.7	2,003,320.3	74,013.4	96.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 464,424.2 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоор 520.0 мянга нийт 464,944.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, архивын гэрээт ажилчдын цалинд 65,558.6 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 62,276.0 мянга, нормативт зардалд 315.0 мянга, урсгал засварын зардалд 6,452.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 84,698.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 240,556.5 мянга, нийт 459,857.1 мянган төгрөгийг зарцуулж 5,087.1 мянган төгрөгийг орон нутагт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

(мянган төгрөг)

№	ЭХ ҮҮСВЭРИЙН	
	Төрөл	Дүн
1	Тусгай зөвшөөрөл	520.0
2	Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл	42,444.9
3	UNITED NATIONS CHILDRENS FUND /НҮБ/	55,000.0
4	Бүгд найрамдах Хятад ард улсын Элчин сайдын яам	15,000.0
5	Япон улсад төвтэй хүүхдийг ивээх сан	2,400.0
6	Гэрээт ажилтны цалин	64,780.3

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан		
7	Сангийн яам-бүх ард түмний их наадмын зардал	200,000.0
8	Түрээсийн орлого	1,560.0
9	Газрын түрээсийн орлого	14,000.0
10	Орон нутагт тасралтгүй 5 жил ажилласан төрийн захиргааны албан хаагчийн урамшуулал	62,342.0
11	Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтын зардал	5,320.0
12	Дээврийн засварт-Баянхонгор ТАГ	1,577.0
	Нийт дүн	464,944.2

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

1. Бүтэц орон тоог аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 11, гүйцэтгэх 55, үйлчлэх 30, нийт 96 орон тоог баталсан бөгөөд тодотголоор 90 орон тоотой болгон 6 архивын гэрээт ажилтныг цомхотгон хүүхэд асрах чөлөөтэй байсан 4 албан хаагч ажилдаа орж тайлант оны эцэст 94 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2. Тус байгууллагын төсөвт хоолны зардлыг 405,548.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 398,792.0 мянган төгрөгийг зарцуулсан ба Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.4 дэх заалтыг үндэслэн өдрийн 20.0 мянган төгрөгөөр тооцон олгосон байна.

3. Сургалт, семинарын 42,960.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тайлант онд 15 төрлийн сургалтыг зохин байгуулж 42,960.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

4. Гадаад томилолтын зардалд 2,002.0 мянган төгрөг батлагдсан СТСХ-ийн мэргэжилтэн Тайланд улсад жижиг дунд үйлдвэрлэлийн сургалтад хамрагдах ад зарцуулсан байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөгөөний батлагдсан зардлаас гадаадад зохион байгуулагдсан 6 арга хэмжээнд 90,017.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

5. Тайлант онд хэвлэл мэдээллийн 8 аж ахуй нэгжтэй 34,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 30,000.0 мянган төгрөгийг шилжүүлж 4,000.0 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн ЗДТГ-ын даргын 2025.01.28-ны өдөр баталсан "Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд 100,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор аймгийн ЗДТГ-т шатахуун нийлүүлэх", 36,000.0 мянган төгрөгийн "Баянхонгор аймгийн ЗДТГ-т бичиг хэргийн материал нийтүүлэх" 2 тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Шатахуун нийлүүлэх тендерийг 3 удаа, бичиг хэргийн материал нийлүүлэх тендерийг 2 удаа зохион байгуулж, шатахуун нийлүүлэх гэрээг "НИК" ХХК-тай 95,794.3 мянга, бичиг хэргийн материал нийлүүлэх гэрээг "Хадат бодь" ХХК-тай 34,946.3 мянган төгрөгөөр тус тус байгуулсан байна.

Гүйцэтгэлээр "НИК" ХХК-д 101,769.6 мянга, "Хадат бодь" ХХК-д 45,092.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ЗДТГ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2/108 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас ангилагдаагүй хөрөнгийг хассан 5,812,680.9 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас ангилагдаагүй хөрөнгийг хассан 5,812,680.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 58,126.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 37,782.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас бэлэг дурсгалд 11.7 хувь буюу 108,280.0 мянган мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 5.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 169 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 8,357,091.1 мянган төгрөгийн 71 гүйлгээ, зарлагын 3,105,187.8 мянган төгрөгийн 177 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 307,444.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 343,435.9 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлээгүйг нөхөн мэдээлүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 465,952.5 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 20,250.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, зөрчлийг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх 441,023.9 мянган төгрөгийн 6 албан шаардлага өгч, 4,678.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын 2025.05.23-ны өдрийн 2/725 тоот албан бичгээр төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	4,678.6	1	4,678.6	100
Албан шаардлага	6	441.023.9	6	441.023.9	100
Зөвлөмж	1	20,250.0	1	20,250.0	100
Нийт дүн	8	465,952.5	8	465,952.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн ТЕЗ-ийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

2. Аймгийн Засаг даргын 2025 оны 61 дүгээр захирамжаар 19,840.0 мянган 11 нэр төрлийн 17 ширхэг хөгжмийн зэмсэг, А/62 дугаар захирамжаар 17,300.0 мянган төгрөгийн хивсийг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид, А/186 дугаар захирамжаар 19,930.0 мянган төгрөгийн 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг Нэгдсэн эмнэлэгт Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас худалдан авч өгсөн нь “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчсөн тул дараагийн аудитаар хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн эсэхийг хянах шаардлагатай.

3. Аймгийн Засаг даргын 2025.06.18-ны өдрийн “аймгийн ИТХ-ын ажлын албаны Toyota Land Criuser 200 маркийн автомашины засварын ажилд хөрөнгө зарцуулах тухай” А/375 дугаар захирамжаар 10,000.0 мянга, Засаг даргын 2025.07.05-ны өдрийн “Замын цагдаагийн тасагт дэмжлэг үзүүлэх тухай” Б/45 дугаар захирамжаар 2,000.0 мянга, Засаг даргын 2025.10.03-ны өдрийн “ШШГГ-ын Nissan patrol Y-62 маркийн автомашины засварын зардалд дэмжлэг үзүүлэх тухай” А/542 дугаар захирамжаар 6,600.0 мянга, нийт 18,600.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас бусад байгууллагын авто машины урсгал засварт зарцуулсан ба дараагийн аудитаар анхаарах шаардлагатай.

4. Иргэний сүүний үйлдвэрийн хөрөнгө нь аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй ба хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байгаад аймгийн удирдлагууд анхаарах шаардлагатай. Иймд дараагийн аудитаар дээрх хөрөнгийг ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт хийх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 704.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагыг 704.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 140,900.7 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, 363.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 140,537.0 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 11,188.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 37,782.4 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 26,593.7 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн 3 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг 60-70 хувиар тооцон 363.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшууллын 363.7 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудтай тооцоо хийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох тухай" Б/39 дугаар тушаалаар 2025 оны 3 дугаар сард 3,696.0 мянган төгрөг, нарийн бичгийн даргад 1-11 дүгээр сард 2,828.0 мянган төгрөг, нийт 6,524.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

5.2.2. Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/25 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад балансын урамшуулалд 2,301.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Урсгал засварын зардлаас “Модерн цогц шийдэл” ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр нэг бүр нь 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн үнэтэй 10 ширхэг, нийт 2,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг (эргэдэг сандал) зориулалт бусаар авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Ангилал шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2023 оны 211 тушаалаар баталсан төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4. Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 20,156 м²-р, газрын эзэмших гэрчилгээнд 13,782 м², цахим мэдээллийн санд (egazar.gov.mn)-д 13.782 м²-р тус тус зөрүүтэй бүргэгдсэн байна

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 17.12-т “Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.5. Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын газар эзэмших эрхийг иргэнд шилжүүлэх тухай” А/637 дугаар захирамжаар Рашаант 10 дугаар багт байрлах 6409009267 нэгж талбарын дугаар бүхий 1300м² талбайтай газрыг нийтийн орон сууц барих зориулалтаар иргэнд шилжүүлсэн ба түншлэлээр бий болсон 129,712.0 мянган төгрөгийн өртөг бүхий 58.96 м² орон сууцыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түншлэлээр бий болсон 129,712.0 мянган төгрөгийн үнэ бүхий орон сууцыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн хөрөнгөд бүртгэж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад төлбөрийн акт, албан шаардлагад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд орлого, зарлагыг илүү бүртгэсэн	1	704.0	-	-	1	704.0	1	704.0	-	-
Дүн	1	704.0	-	-	1	704.0	1	704.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн 3 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг 60-70 хувиар тооцон 363.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	363.7	1	363.7	-	-	-	-	-	-
Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох тухай” Б/39 дугаар тушаалаар 2025 оны 3 дугаар сард 3,696.0 мянган төгрөг, нарийн бичгийн даргад 1-11 дүгээр сард 2,828.0 мянган төгрөг, нийт 6,524.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	6,524.0	-	-	1	6,524.0	-	-	-	-

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/25 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад балансын урамшуулалд 2,301.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	2,301.0	-	-	1	2,301.0	-	-	-	-
Урсгал засварын зардлаас “Модерн цогц шийдэл” ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр нэг бүр нь 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн үнэтэй 10 ширхэг, нийт 2,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг (эргэдэг сандал) зориулалт бусаар авсан байна.	1	2,000.0	-	-	1	2,000.0	-	-	-	-
Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 20,156 м2-р, газрын эзэмших гэрчилгээнд 13,782 м2, цахим мэдээллийн санд (egazar.gov.mn)-д 13.782 м2-р тус тус зөрүүтэй бүргэгдсэн байна	1	-	-	-	1	-	-	-	-	-
Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын газар эзэмших эрхийг иргэнд шилжүүлэх тухай” А/637 дугаар захирамжаар Рашаант 10 дугаар багт байрлах 6409009267 нэгж талбарын дугаар бүхий 1300м2 талбайтай газрыг нийтийн орон сууц барих зориулалтаар иргэнд шилжүүлсэн ба түншлэлээр бий болсон 129,712.0 мянган төгрөгийн өртөг бүхий 58.96 м2 орон сууцыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	129,712.0	-	-	1	129,712.0	-	-	-	-
Дүн	6	140,900.7	1	363.7	5	140,537.0	-	-	-	-

-----oOo-----